



**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”  
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР**

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027  
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,  
Цахим шуудан: info@erdenetmc.mn,  
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.11.01 № 07-172-12/6941  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай


“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан “Баяжмалын уутны бэлдэц I” нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/20240102005 дугаартай нээлттэй тендерт оролцогч ТМА тээвэр ложистикийн үйлчилгээ компани 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 176/24 дүгээр тодруулга гаргасан тул тодруулгын хариуг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт ... хуудастай.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН  
АВАХ АЖИЛЛАГААНЫ БОДЛОГЫН  
ГАЗРЫН ДАРГА



С.ЭНХМАНДАХ



1.Тус тендерийн ТШЗ 1.3 Дотоодын үйлдвэрээс худалдан авах : "Бараатай" Дотоодын үйлдвэрээс худалдан авах : "Бараатай" ТБОНӨХБАУАТХ-ийн 8.1 Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой, чанар стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авна. Монгол улсын Засгийн газрын 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-ын "9.2. Хүнд даацын шуудай, шуудайн бэлдэц;"-д хамаарагдах тендер шалгаруулалт, эсхүл түүний багцад зөвхөн Монгол улсын гарал үүсэлтэй бараа нийлүүлнэ гэж тодорхой заасан.

2.ТШЗ 16.3 Гадаадын этгээд оролцох эрхтэй эсэх : "Эрхтэй" Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

-хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг; - гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг; - тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

[ТБОНӨХБАУАТХ хуулийн 26.10.Энэ хуулийн 26.9-д зааснаас бусад тендер болон дараах тендерийг шаардлага хангаагүй гэж үзэж татгалзана: 26.10.2.Энэ хуулийн 8.1-д заасны дагуу зохион байгуулсан дотоодын барааны багцад импортын бараа санал болгосон бол татгалзах үндэслэл болно] гэж тодорхой заасан болно.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.3.Захиалагч ажлын хувьд 30 тэрбум, барааны хувьд нэг тэрбум, үйлчилгээний хувьд 300 сая төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно гэж заасны дагуу гадаадын этгээд оролцохыг хориглоогүй бөгөөд хэрэв гадаадын этгээд оролцох бол тус хуулийн 8.1-д заасны дагуу зохион байгуулсан дотоодын барааны багцад импортын бараа санал болгосон бол татгалзах үндэслэл болно буюу импортын бараа бүтээгдэхүүнээр оролцох боломжгүй юм.

ХЯНАСАН:

БАРАА, МАТЕРИАЛ ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА:

 Д.БАТХИШИГ

БОЛОВСРУУЛСАН:  
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА:

 И.БАЯРБАЛ